



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 791

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 17 нэрийн, нийт 306,139,700.00 (гурван зуун зургаан сая нэг зуун гучин есөн мянга долоон зуу) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 193,401,600.00 (нэг зуун ерэн гурван мянга дөрвөн зуун нэг мянга зургаан зуу) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн зохицуулагч Ж.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

өмчийн бодлого, зохицуулалтын га
 24 онь 12 дугаар сарын 30-ны өд
Уул..... дугаар тогтоолын хавс
 ЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮН

"Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Код	Ашиглагтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа /жилээр/	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
Машин, тоног төхөөрөмж										
1	Принтер Xerox Versa link C7020	00000970	6/4/2019	1	ш	11,000,000.00	11,000,000.00	1	4,400,000.00	4,400,000.00
2	Компьютер i7 9700k, Dell U2719H	00000965	6/4/2019	3	ш	7,040,000.00	21,120,000.00	2	2,500,000.00	7,500,000.00
3	Компьютер i7 9700k, Dell U2719H	00000965	6/4/2019	1	ш	7,040,000.00	7,040,000.00	2	1,800,000.00	1,800,000.00
4	Компьютер Dell 7060, Dell E2418N	00000966	6/4/2019	9	ш	3,674,000.00	33,066,000.00	1	1,800,000.00	16,200,000.00
5	Зөөврийн компьютер /Dell G7/	00000967	6/4/2019	4	ш	3,410,000.00	13,640,000.00	1	1,500,000.00	6,000,000.00
6	Айпад /Ipad Pro 11"/	00000968	6/4/2019	3	ш	3,520,000.00	10,560,000.00	1	1,200,000.00	3,600,000.00
7	Айпад /Ipad mini 5/	00000969	6/4/2019	1	ш	2,310,000.00	2,310,000.00	1	600,000.00	600,000.00
8	Дрон /DJI Mavic pro 2dron/	00001004	7/10/2019	1	ш	4,250,000.00	4,250,000.00	1	1,800,000.00	1,800,000.00
9	5к дэлгэц	00000401	2017.11.27	1	ш	866,000.00	866,000.00	1	500,000.00	500,000.00
10	Хөргөгч konka 185л	00001472	2/25/2021	1	ш	595,000.00	595,000.00	1	238,000.00	238,000.00
11	Угаалгын машин PR 10кг	00001473	2/25/2021	1	ш	300,000.00	300,000.00	1	120,000.00	120,000.00
12	Печь Media	00001474	2/25/2021	1	ш	234,000.00	234,000.00	1	93,600.00	93,600.00
13	Будаа агшаагч phillips	00001475	2/25/2021	1	ш	150,000.00	150,000.00	1	60,000.00	60,000.00
Хэсгийн дүн				28			105,131,000.00			42,911,600.00
Тээврийн хэрэгсэл										

Д/д	Хөрөнгийн нэр	Код	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа /жилээр/	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
14	Тоёота ланд крузер-200 маркийн, 09-06 УНУ улсын дугаар, JTMHX05J004136640 арлын дугаар	00001388	2017	1	ш	200,000,000.00	200,000,000.00	5	150,000,000.00	150,000,000.00
Хэсгийн дүн				1			200,000,000.00			150,000,000.00
Тавилга, эд хогшил										
15	Сандап А654-3TG	00000550	2014.05.13	3	ш	149,600.00	448,800.00	1	60,000.00	180,000.00
16	Шкаф LGD S 750	00000045	2013.08.22	1	ш	339,900.00	339,900.00	5	150,000.00	150,000.00
17	Тавиур архивын төмөр	00000046	2014.03.17	2	ш	110,000.00	220,000.00	5	80,000.00	160,000.00
Хэсгийн дүн				6			1,008,700.00			490,000.00
				35			306,139,700.00			193,401,600.00
Нийт дүн							(гурван зуун зургаан сая нэг зуун гучин есөн мянга долоон зуу)		(нэг зуун ерэн гурван мянга дөрвөн зуун нэгэн мянга зургаан зуу)	